




НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хувьсгалчдын өргөн чөлөө-15,
Нийслэлийн Засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>,
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.03.10. № 02-01/159.

танай _____ -ны № _____ -т

ДАРГА БАТЛАВ Л.ЭРДЭНЭЧУЛУУН



Судалгаа шинжилгээ, хил гаалийн болон аюулгүйн үзлэг шалгалтад цацрагийн үүсгүүр ашиглаж буй байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт хийхээр зарласан цацрагийн үүсгүүр болон рентген багаж, тоног төхөөрөмж ашиглан, үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Агаарын тухай хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Цөмийн энергийн комиссын 2016 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”, 2015 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Цацрагийн аюулгүйн норм”, “Цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын цацрагийн аюулгүйн албаны дүрэм”, 2015 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангах дүрэм”-ийн мөрдөлтөд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, санал дүгнэлт гаргах замаар эрсдэлийг бууруулах, цацрагийн аюулгүй байдлыг хангуулахад оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

Төлөвлөгөөт хяналт шалгалт

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр

Удирдамжийн хавсралтад нэр заагдсан, 2017 оны хяналт шалгалтад хамруулахаар зарласан, нийслэлийн нутаг дэвсгэрт цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа эрхэлж буй нийт 10 байгууллага хамрагдана. (Хавсралт 1)

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч Ш.Сандаг-Очир ахалж,
улсын байцаагч Ч.Өсөхжаргал хийж гүйцэтгэнэ.

001150504893

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

Хяналт, шалгалтын ажлыг 2015-2016 онуудад Цөмийн энергийн комиссын Ажлын алба, Буянт-Ухаа дахь Гаалийн газар, Чингис хаан Олон улсын нисэх буудал, Геологийн төв лаборатори Төрийн өмчит үйлдвэрийн газар, Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль, Мал эмнэлгийн хүрээлэн, Монгол Ви И Ти Нет төрийн бус байгууллагын Энэрэх мал эмнэлэг, Интерсайнс ХХК зэрэг байгууллагуудад Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын хэлтсээс тус тус хийж гүйцэтгэж байсан.

Төлөвлөгөөнд орсон Улаанбаатар хотын цагдаагийн газар, “Бьюри Веритас Инспекшэнь Тестин Монголиа” ХХК нь хяналт шалгалтад хамрагдаагүй.

Долоо. Хяналт шалгалтын чиглэл

7.1. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу 10.1 кодтой “Цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 10.3 кодтой “Рентген багаж, тоног төхөөрөмжийн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ны шалгах асуулт бүрээр шалгаж, эрсдэлийг үнэлэх, үнэлгээнд тулгуурлан эрсдэлийн дүн шинжилгээ хийх;

7.2. Аюулгүйн үзлэг, шалгалт болон судалгаа шинжилгээний зориулалттай рентген багаж, тоног төхөөрөмж, цацраг идэвхт үүсгүүрийн гадаргууд, ойр орчимд цацрагийн тунгийн чадлын хэмжилт хийх, ажлын байранд цацрагийн эрүүл ахуй-дозиметрийн хэмжилтүүдийг хийж гүйцэтгэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, байгууллагын сургалт зохион байгуулах;

7.3. Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтыг гүйцэтгэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

7.4. Байгууллагуудад ашиглагдаж, хадгалагдаж буй цацрагийн үүсгүүр, рентген багаж, тоног төхөөрөмжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэх;

7.5. Тусгай зөвшөөрөлгүйгээр буюу тусгай зөвшөөрөлд заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан, тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу хуульд заасан хугацаанд сунгуулаагүй, цацрагийн аюулгүй байдлыг хангуулаагүй тохиолдолд лац тавьсан тухай тэмдэглэл хөтлөн улсын байцаагчийн актаар хэсэгчлэн болон бүхэлд нь үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээг авах;

7.6. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгөх;

7.7. Хяналт шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагуудад Агаарын тухай хууль, Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам, Монгол Улсын MNS 5043:2016, MNS 5216:2016 стандартуудын хэрэгжилтэд хяналт тавьж, агаар бохирдуулагч эх

үүсвэрийн талаар судалгаа авах, дүрэм, журам, стандартыг хангуулах, сурталчлах;

7.8. Хяналт шалгалтын явцад аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай, холбоотой олж авсан мэдээллийн нууцыг холбогдох хуулийн дагуу хяналт шалгалт хийсэн улсын байцаагч бүрэн хариуцах;

7.9. Хяналт, шалгалт хийх, захиргааны акт гаргах, хариуцлага хүлээлгэх, эдгээрийг бэлтгэх, хэлэлцэх, оролцох, ажлын хэсэг ахлах зэрэгт ажиллахын өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэхээр бол албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг менежерт тухай бүр гаргаж, эрх бүхий албан тушаалтанд бүртгүүлэх;

7.10. Бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөлөл, албан үүрэгтэй холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд татгалзаж, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл энэ талаарх тайлбараа бичгээр гаргаж, менежерт хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх;

7.11. Хяналт шалгалтын үйл ажиллагааг холбогдох баримт бичиг, судалгаа, фото зураг, дүрс бичлэгээр баталгаажуулах;

Найм. Шалгалтын дүнг нэгтгэх, тайлагнах

8.1. Хяналт, шалгалтын дүнг шалгагдсан байгууллагын удирдлагуудад танилцуулах;

8.2. Хяналт, шалгалтын ажлын танилцуулга бичиж, холбогдох удирдлагуудад танилцуулах;

8.3. Хяналтын ажлын мөрөөр цацрагийн аюулгүй байдлыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг эргэж хянах;

8.4. Хяналт, шалгалтын дүнг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан календарчилсан төлөвлөгөөний дагуу 2017 оны 10 дугаар сарын 25-ны дотор газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар оруулах;

8.5. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн шалгалтын талаарх мэдээллийг бүртгэлийн нэгдсэн сан шилэн хяналтад оруулах;

8.6. Шалгалтын дүнгийн талаар "Олон нийтэд мэдээлэх журам"-ын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

БОЛОВСРУУЛСАН:
ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  САНДАГ-ОЧИР

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Ч.ӨСӨХЖАРГАЛ

НМХГ-ын даргын баталсан 2017 оны 03
дугаар сарын 10 - ны өдрийн 02-01/159
тоот удирдамжийн хавсралт

УХА0348

ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГУУД

| Д/д | Байгууллагын нэр | Хяналт хийх хугацаа | Хяналт хийх улсын байцаагч |
|--|---|-----------------------|---|
| I | II | III | IV |
| Аюулгүйн үзлэг, хяналтад ашиглагдаж буй рентген тоног төхөөрөмжүүд | | | |
| 1 | Улаанбаатар хотын Цагдаагийн газар | 04-06 дугаар саруудад | Улсын ахлах байцаагч Ш.Сандаг-Очир |
| 2 | Буянт-Ухаа дахь Гаалийн газар | | |
| 3 | Чингис хаан Олон улсын нисэх буудал | | Улсын ахлах байцаагч Ш.Сандаг-Очир Улсын байцаагч Ч.Өсөхжаргал |
| 4 | "Бьюри Веритас Инспекшэнь Тестин Монголиа" ХХК | | |
| I | II | III | IV |
| Судалгаа шинжилгээний зориулалтаар ашиглаж буй рентген багаж, тоног төхөөрөмжүүд | | | |
| 5 | Цөмийн энергийн комиссын Ажлын алба | 04-06 дугаар саруудад | Улсын байцаагч Ч.Өсөхжаргал |
| 6 | Мал эмнэлгийн хүрээлэн | | |
| 7 | Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургууль | | |
| 8 | Геологийн төв лаборатори Төрийн өмчит үйлдвэрийн газар | | |
| 9 | Интерсайнс ХХК | | |
| 10 | Монгол Ви И Ти Нет төрийн бус байгууллагын Энэрэх мал эмнэлэг | | |